

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2024 оны 08 дугаар сарын 29-ний өдөр, Пүрэв гараг**

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-2

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 3-14

1.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ./ 6-14

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит бус чуулганы
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны
08 дугаар сарын 29-ний өдөр /Пүрэв гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 72.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 02 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Ч.Анар, Э.Болормаа, Р.Эрдэнэбүрэн;

Эмнэлгийн чөлөөтэй: П.Сайнзориг;

Тасалсан: Б.Энхбаяр.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат, Ж.Энхбаяр нар үг хэлж, Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн тайлбар хийв.

Нэг.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Б.Тулга, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч Я.Самбууням, Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, мөн газрын аудитын менежер П.Чанцалдулам, Б.Лхагвацэнд, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, аудитын менежер Ю.Энхтуяа, ахлах аудитор У.Оюунхүү, аудитор Б.Идэрбалжинням, Д.Нямжаргал, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганхуяг, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Оюунгэрэл, Гадаад харилцааны яамны Бодлогын газрын захирал Г.Бямбасүрэн, мөн яамны Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга Ч.Ганбат, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төрийн сангийн газрын дарга Б.Цогбадрах, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Санхүүгийн бодлогын газрын дарга Л.Сонор, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Санхүү, хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга Н.Мөнхсүх, Төлбөр, тооцооны хэлтсийн дарга В.Рэнцэнханд, Гаалийн ерөнхий газрын дарга Р.Отгонжаргал, Онцгой байдлын ерөнхий газрын дэд дарга Б.Ууганбаяр, мөн газрын Төсөв, санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Т.Мөнх-Эрдэнэ, Цөмийн энергийн комиссын нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга Г.Манлайжав, Зэвсэгт хүчний Жанжин штабын Санхүүгийн хэлтсийн ахлах мэргэжилтэн П.Эрдэнэбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, референт Б.Гандиймаа нар байлцав.

Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн талаарх илтгэлийг Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Б.Тулга, нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав нар танилцуулав.

Илтгэл болон аудитын дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Энхбаяр, Д.Ганбат нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Я.Самбууням, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат нар хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Хосбаяр Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 47 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 45 минут үргэлжилж, ирвэл зохих 25 гишүүнээс 20 гишүүн хүрэлцэн ирж, 80.0 хувийн ирцтэйгээр 12 цаг 47 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
АЮУЛГҮЙ БАЙДАЛ,
ГАДААД БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 08 дугаар сарын 29-ний өдөр,
Пүрэв гараг
Төрийн ордон “Их засаг” танхим
12 цаг 02 минут.

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Тэмүүлэн: Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаан эхлэхэд бэлэн болсон байна. Гишүүд маань бас хуралдааныхаа танхимд хүрэлцэн орж ирээрэй. 9 цагаас эхлэх байсан бас хүлцэл өчье. Тодорхой Улсын Их Хурал дээрх хурлууд бас давхцаад, тодорхой хугацаагаар хойшлогдлоо. Ирцийг би танилцуулж байя. Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаан дээр Очирбатын Амгаланбаатар гишүүн ирсэн байгаа. Наранцэцэгийн Алтаниагай гишүүн ирсэн байна. Энхтайвангийн Бат-Амгалан гишүүн хүрэлцэн ирсэн байна. Батын Батбаатар гишүүн хүрэлцэн ирсэн байна. Нацагдоржийн Батсүмбэрэл гишүүн хүрэлцэн ирсэн байна. Дашидондогийн Ганбат гишүүн хүрэлцэн ирсэн байна. Борхүүгийн Дэлгэрсайхан, Хажсекберийн Жангабыл, Батбаярын Жаргалан, Нанзадын Наранбаатар, Пүрэвсүрэнгийн Наранбаяр, Нянтайширын Номтойбаяр, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин, Ганбатын Хосбаяр, Дамдины Цогтбаатар, Жадамбын Энхбаяр, Лутаагийн Энхнасан, Сүхбаатарын Эрдэнэболд нарын гишүүд хүрэлцэн ирсэн байна.

Ингээд нийт Байнгын хорооны гишүүдийн дийлэнх нь хүрэлцэн ирсэн тул Байнгын хорооны 2024 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье. Та бүхэнд хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Байнгын хорооны хуралдаанаар өнөөдөр хэлэлцэх асуудал нэг байгаа. Монгол Улсын нэгдсэн

төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөлд Засгийн газар 2024 оны 8 дугаар сарын 12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлэхээр болбол заагдсан байгаа. Хэлэлцэх асуудалтай холбогдуулаад саналтай гишүүд байна уу? Байна. Ганбат гишүүн саналтай байна. Ганбат гишүүний микрофоныг өгье.

Д.Ганбат: Та бүхний амар амгаланг айлтгая. Ер нь бид нар бас нэг цагаа барьж хуралдаж байвал зүгээр байх юм. Өглөө 9 цагт ингээд зарласан. Тэгээд ямар учраас, ямар шалтгаанаар хойшилоод байдаг юм бас мэдэхгүй байна. Энэ чинь Байнгын хорооны хурал гэдэг чинь цагтаа эхлээд, цагтаа ингээд нартай явж баймаар байна 1 дүгээрт.

2 дугаарт бид нар Төсвийн тухай хуулийг ярьж байна. Төсвийн тодотголыг ярьж байна. Төсвийн гүйцэтгэл ярьж байна. Энэ бүх зүйлүүд маань хуулийн дагуу явахгүй байгаа шүү гэдгийг анхааруулъя. Угаасаа олон түмнээр хэлэлцүүлээд, тодорхой цаг хугацаа гаргаж өгөөд, нарийн нягт нямбай үзэж үзсэнийхээ үндсэн дээр энэ татвар төлөгчдийн мөнгө хаашаа, яаж зарцуулагдаад байгаа, үр дүн нь ямар байгаа гэдгийг бид нар бас нэлээн сайн ярилцах ёстой байтал тэгээд л үүр шөнийн заагаар нэг иймэрхүү л хууль баталж гаргаж ирээд л, тэгээд л цаг хугацаагаар шахдаг ийм байдалтай байна гэдгийг анхааруулъя.

Үүнээс гадна бас энэ Улсын Их Хурал маань бүрэлдээд ингээд 2, 3 сар болчихлоо. Энэ манай Аюулгүй байдлын байнгын хорооны харьяа нэг Байнгын хороо дэд хороод дутуу байна. Энийг ажилд нь оруулахгүйгээр энэ төсвийн гүйцэтгэл, төсвийн тодотгол энэ бүх юмнуудыг хэлэлцээд байж болж байгаа

юм уу? Энэ хууль зөрчигдөж байна, хуулийн дагуу ерөөсөө явахгүй байна. Төрийн ажил бол хуулийг мөрдөж, хуулийн дагуу явж байх ёстой. Энэ дээрээ Улсын Их Хурал манай Байнгын хороо анхааръя.

Тэгээд энэ хэлэлцэх асуудлын эхэнд нь бол энэ Тусгай хяналтын дэд хороог байгуулж, ажилд нь оруулах энэ хуулийн зөрчлийг засах, энэ алдааг засах энэ ажлыг хууль тогтоогчид бид бүхэн хийх шаардлагатай гэж бодож байна. Ингээд Тусгай хяналтын дэд хорооны бүтэц, бүрэлдэхүүнийг батлах, ажилд нь оруулах ийм горимын саналтай байна. Өнөөдрийн хуралдаанаар энэ асуудлыг шийдвэрлэхгүй бол 30-наар өнөөдөр чинь тэгээд энэ ээлжит бус чуулган чинь завсарлах гээд байна шүү дээ. Ийм саналтай байна. Гишүүд дэмжиж өгнө үү.

Г.Тэмүүлэн: Энхбаяр гишүүн бас хэлэлцэх асуудалтай холбогдуулж санал гаргаж байна. Энхбаяр гишүүн, Ж.Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

Ж.Энхбаяр: Гишүүдийнхээ амрыг эрье. Сая 23 оны төсвийн гүйцэтгэлийг Байнгын хороод хэлэлцээд үндсэндээ ингээд дуусах.../үг тасрав/

Г.Тэмүүлэн: Техникийн алдаа гарах шиг боллоо Ж.Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

Ж.Энхбаяр: 23 оны төсвийн гүйцэтгэлийг хэлэлцлээ. Уг нь хууль ёсоор нэгэнт Их Хурлын бүрэн эрх хэрэгжсэн нөхцөлд Их Хурлын харьяа хороод болон дэд хороод яаралтай байгуулагдаж, үйл ажиллагаа нь жигдрэх ёстой. Төсвийн гүйцэтгэл дээр бид 23 оны төсвийн гүйцэтгэл дээр энэ Тусгай хяналтын дэд хороогоор заавал ордог гүйцэтгэх ажиллагаатай холбоотой болон маш нууц төслүүдтэй холбоотой асуултууд гүйцэтгэлүүд хэрэгжилтийг харах ёстой. Тэр хийгдсэнгүй.

Дахиад төсвийн тодотгол явлаа 24 оны. Мөн адил Тусгай хяналтын хороон дээр явагдах ёстой, тодруулах ёстой олон төсөл хөтөлбөрийн асуудлууд хэлэлцэгдсэнгүй. Шинэ цаглавраар Засгийн газар 9 сарын 1-ний дотор Улсын Их Хуралд 25 оны төсвийг өргөн барьж байгаа. Төсөв өргөн баригдсан өдрөөс Их Хурлын мэдэлд шилждэг. Ингээд Улсын Их Хурлын дэд болон бусад хороод ажиллагаанд орох ёстой. Иймд мөн адилхан дараагийн хуулийн зөрчил үүсэх ийм байдал үүсчхээд байна. Тэгэхээр энийг Байнгын хорооны гишүүддээ нэг яаралтай залруулаад нэг мөр шийдэх ёстой. Тэгэхгүй бол Байнгын хороо маань өөрөө хуулийн зөрчилд орно гэдгийг нэг болгоогоод. Бүлгүүдээс миний ойлгож байгаагаар бүлгүүдээс санал өгчихсөн байгаа.

Тэгэхээр энэ Байнгын хороо өөрөө онцгой чухал улс орны өмнө нэлээн томоохон хариуцлага хүлээдэг түр байнгын хороо юу дэд хороо байдаг. Тэгэхээр дэд хороог яаралтай ажилд нь оруулахгүй бол бусад байгууллагуудын төсвийн асуудал хүндэрч байна сая. Тэр төсвийн асуудлаа хэнтэй, хаагуур ярих вэ гэдэг асуудал. 2 том, 1 том асуудал байгаа биз. Төсөв 9 сарын 1-нээр Засгаас өргөн бариад л гарчхаж байгаа юм. Их Хурал ажиллах ёстой болж байгаа юм. Гэтэл ээлжит бус чуулган маань ээлжит чуулган маань 10 сарын 1 шүү дээ. Тэгэхээр ийм том бодлогын ийм том 2 хуулийн ийм зөрчил үүсчихсэн.

Хэрвээ 10 сарын 1-нээс төсөв өргөн бариад явдаг байсан бол нэг болно гэж ойлгох сон. Даанч шинэ хуулиар шинэ Төсвийн хуулиар тэр 9 сарын 1-нээс хууль төсөв өргөн барьдаг болчихоор чинь ерөөсөө болохгүй болчихоод байгаа юм. Тэгэхээр Ганбат гишүүний гаргасан санал зарчмын хувьд их зүйтэй санал. Тэгээд шийдээд явах ёстой гэж үзэж байгаа юм.

Г.Тэмүүлэн: 1 дүгээрт Ганбат гишүүнээс бас хүлцэл өчье. Ямар ч байсан өнөөдрийн Байнгын хорооны хуралдаан

маань бас хугацаандаа бас эхэлж чадаагүй, хугацаандаа эхэлж чадаагүй. Тодорхой бас бүлэг, Улсын Их Хурлын харьяалах Байнгын хороод бас давхцаад, дээрээс бас тодорхой хойшлуулах чиглэлийн хүрээнд бас ингээд хойшиллоо.

Би 1 дүгээрт саяын тэр дэд хороотой холбоотой асуудлууд дээр нэг тайлбар та бүхэнд бас өгье. Тэгээд ер нь яагаад манайх ингээд хойшлоод удаад байна вэ гэдэг асуудал. Хувийн талаасаа бол энэ дээр түргэн шуурхай байгуулаад, энэ асуудлыг нь хэлэлцээд шийдвэрлэх нь болбол зарчмын асуудал болоод байгаа юм. Улсын Их Хурлынхаа тухай хуулиар болоод Улсын Их Хурлын дэгийн тухай хуулиараа нөгөө Байнгын болоод дэд, хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүний талаар болбол Улсын Их Хурлын даргатай зөвшилцөх гэдэг энэ заалт байгаад байгаа. Ингээд энэ дагуу улс төрийн нам, бүлгүүд тодорхой тухайн тэр дэд хороонд оруулах бүрэлдэхүүнийхээ нэрсийг болбол бас албан ёсоор Улсын Их Хурлын даргад хүргүүлж, Улсын Их Хурлын дарга наашаа цохиж, Байнгын хороонд бид нар хэлэлцэх энэ процесс болбол хөдлөхөөр байгаад байгаа юм.

Ингээд одоогоор болбол 2 намын бүлэг болбол яах вэ урьд нь бол бичиг өгсөн, буцаагаад бичгээ болбол татлаа. Бид нар энэ дээр болбол тодорхой бас бүлгээрээ ярилцаж, өөрчлөлт оруулах, тухайн тэр бүрэлдэхүүнийхээ асуудлыг эцсийн шийдвэрт хүрэх шаардлагатай байна гэсэн хүсэлтүүдийг аль, аль бүлгүүд болбол бас ирүүлээд байгаа юм. Тэрнээс ямар нэг байдлаар өөрөөр бол манай Байнгын хорооноос хамааралтайгаар энэ асуудлыг хойшлуулж байгаа, удааж байгаа, асууж гацааж байгаа зүйл бол байхгүй. Тэгэхээр 2 намын бүлгүүд бас өөрсдөө энэ дээр түргэн шуурхай Их Хуралдаа бас тодорхой Байнгын хороондоо хүндэтгэлтэй хандаж, саналуудаа эцэслэн ирүүлэх болбол зайлшгүй шаардлагатай байна л гэсэн ийм саналыг болбол хэлэх байна.

Өөрсдийнхөө ирүүлсэн саналуудыг бол буцаж татаж байгаагаа болбол 2 бүлгийн дарга нар бол бас өөрсдөө илэрхийлж хэлсэн байгаад байгаа. Тийм. Ганбат гишүүн нэмж тодруулъя.

Д.Ганбат: Уг нь бол энэ ээлжит Улсын Их Хурлын бүрэн эрх хэрэгжээд анх бол би хурлыг зохион байгуулаад, удирдаад ингээд 5 гишүүнтэй төсвийн, дэд хороо байгуулагдсан. Түүн дээр бол манайх бас дараа нь бол гарсан юм билээ. Байнгын хорооны бүрэлдэхүүн бүтэн болоогүй байна 1 дүгээрт. 2 дугаарт бол олон хүмүүс бас гүйцэтгэх засаглал, Батлан хамгаалахын сайд энэ тэр гээд Байнгын хорооны гишүүд ингээд орж байна. Тийм учраас яг энд сонгогдсон хүмүүс маань өөрчлөгдөх ёстой гэж үзсэн.

Манай АН-ын бүлгээс бол саналаа явуулчихсан байгаа, ирчихсэн байна. эгээд хэн нэгнээс болоод ингээд хууль зөрчиж болохгүй. Өмнөх Тусгай хяналтын дэд хороонд миний бие ажиллаж байсан, манай Цогтбаатар гишүүн ажиллаж байсан. Нөгөө 3 хүн маань бас янз бүрийн шалтаг шалтгаанаар зарим нь бас сонгогдоод, зарим нь бас Улсын Их Хурлын сонгуульд ажиллаагүй. Ядаж 3 хүний бүрэлдэхүүнтэй байж энэ хэрэгжинэ. Тэгэхээр ийм шалтаг шалтгаанаар бол бид нар бол энэ улсын төсөв, гүйцэтгэл энэ бүх юмнуудыг ээлжит бус энэ юман дээр бол хууль зөрччихлөө. Ахиад цаашаа хууль зөрчөөд явуулаад байж болохгүй.

Манай Энхбаяр гишүүн ч гэсэн энийг нэлээн сайн тодотгож хэллээ. Энэ бол бас тийм хүндэтгэх юм уу, ийм юутай биш. Та Улсын Их Хурлынхаа даргатайгаа холбоо бариад, тэгээд энэ асуудлыг нэг тийш нь болгосон нь дээр байх гэж бодож байна. Тийм.

Г.Тэмүүлэн: Ганбат гишүүнтэй санал нэг байна зарчмын хувьд бол. Тэгээд би шаардлагатай бол бид нар үдээс хойш

ч гэсэн хуралдаад энэ асуудлыг шийдээж болно. Маргааш ч гэсэн бас Улсын Их Хурлын чуулган байгаа. Чуулганы ээлжит бус хурлын дараа ч гэсэн хуралдах бүрэн боломж бололцоо болбол байгаа. Тэгэхээр дахиад Улсын Их Хурлын даргатай энэ асуудлаар бас зөвшилцөөд, эргээд бас 2 Байнгын хорооны гишүүдэд бас хариу өгье л гэсэн саналтай байна. Тэгвэл хэлэлцэх асуудалдаа орчих уу Ганбат гишүүн ээ? Баярлалаа танд. Тэгье ойлголоо. Ж.Энхбаяр гишүүн болоод Ганбат гишүүдийн саналыг бас ойлгож байна.

Нэг.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ./

Ингээд хэлэлцэх асуудалдаа орцгооё. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай Улсын Их Хурал тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг хуралдаанд оруулцаая. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх илтгэлийг Монгол Улсын сайд, Монгол Улсын Боомтын сэргэлтийн үндэсний хорооны дарга Тулга сайд танилцуулна. 3 номерын микрофоныг өгье.

Б.Тулга: Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгдсэн тайланг хуулийн хугацаанд нэгтгэн гаргаж, Төрийн аудитын төв байгууллагаар аудит хийлгэн, Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит бус чуулганы 8 дугаар сарын 27-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэгт танилцуулсан билээ.

Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл, ЗГ-ын санхүүгийн нэгдсэн тайланд тус Байнгын хороонд харьяалагдах Монгол Улсын Ерөнхий сайд, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Монгол Улсын Шадар сайд онцгой байдлын асуудал эрхэлсэн, Гадаад харилцааны сайд, Батлан хамгаалахын сайдын багцын нийт 112 байгууллагын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг нэгтгэн гаргасан болно.

Нэгдсэн төсвийн гүйцэтгэлээр тус Байнгын хорооны төсвийн ерөнхийлөн захирагчдын нийт зарлага болон цэвэр зээлийн дүн 918,8 тэрбум төгрөгийн гүйцэтгэл гарч, үүнээс урсгал зардалд 849,6 тэрбум төгрөг, хөрөнгийн зардалд 69,2 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. Нийт зарлага болон цэвэр зээлийн дүнгийн 42 хувь буюу 386,3 тэрбум төгрөгийг Батлан хамгаалахын сайд, 24,2 хувь буюу 222,3 тэрбум төгрөгийг Монгол Улсын Ерөнхий сайд, 19,7 хувь буюу 180,9 тэрбум төгрөгийг Монгол Улсын Шадар сайд, 12,5 хувь буюу 115,3 тэрбум төгрөгийг Гадаад харилцааны сайд, 1,5 хувь буюу 14 тэрбум төгрөгийг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зарлага эзэлж байна. Улсын төсвөөс 881,5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон бол төсөвт байгууллагын өөрийн орлогоор 41,9 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлсэн байна.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Та бүхэн 2023 оны төсвийн гүйцэтгэлийн үр дүнгийн тоон үзүүлэлтүүд болон бусад холбогдох тайлан, танилцуулга, аудитын дүгнэлтүүдтэй танилцаж, Төсвийн тухай хуулийн дагуу Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж өгнө үү. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Тэмүүлэн: Нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Дэлэгийн Загджав танилцуулна. 4 номерын микрофоныг өгье.

Д.Загджав: Та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе. Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын тухай хуульд заасан бүрэн эрх, Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн ерөнхийлөн захирагчдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгдсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ. Тус Байнгын хороонд харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл болон улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр дүнд хийсэн аудитын талаар товч танилцуулъя.

1.Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгдсэн тайланд 55 тайлан нэгтгэснээс 5 байгууллагын санхүүгийн тайлан дүгнэлт хийж, 50 байгууллагыг түүвэрт хамрууллаа. Аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд өөрчлөлтгүй, харьяа 4 байгууллагад өөрчлөлтгүй, 1 байгууллагад хязгаарлалттай дүгнэлт өглөө. Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 414,3 сая төгрөгийн 27 зөрчил илэрснээс

5,5 сая төгрөгийн 6 төлбөрийн акт тогтоож, 22,3 сая төгрөгийн зөрчлийг арилгах, 6 албан шаардлага хүргүүлж, 385,4 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 15 зөвлөмж өгсөн. Нягтлан бодох бүртгэл тайлантай холбоотой 5 тэрбум 186 нэг сая төгрөгийн 29 алдаа илэрснийг аудитын явцад залрууллаа. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 186,4 сая төгрөгийн 8 зөрчил илэрснээс 12,2 сая төгрөгийн зөрчлийг арилгах 4 албан шаардлага хүргүүлж, 173,8 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өгсөн.

2.Батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн тайланд 94 тайлан нэгтгэснээс 37 байгууллагын санхүүгийн тайлан дүгнэлт гаргаж, 57 байгууллагыг түүвэрт хамрууллаа. Аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайлан нэгтгэсэн тайланд өөрчлөлтгүй харьяа 31 байгууллагад өөрчлөлтгүй, 6 байгууллагад хязгаарлалттай дүгнэлт өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 3,7 тэрбум төгрөгийн 76 зөрчил илэрснээс 21,5 сая төгрөгийн зөрчилд 4 төлбөрийн акт тогтоож, 2,4 сая, 2,4 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгах 16 албан шаардлага хүргүүлж, 1,3 тэрбум төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 56 зөвлөмж өгсөн. Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 130,4 тэрбум төгрөгийн 20 алдаа илэрснийг аудитын явцад залрууллаа. Санхүүгийн аудит тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудит нийцлийн асуудлаар нийт 3,7 тэрбум төгрөгийн 13 зөрчил илэрснээс 34 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 3,6 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгах 3 албан шаардлага хүргүүлж, 9 зөрчлийг арилгах зөвлөмж өглөө. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 24 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 11,9 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 6 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр

төлөвлөсөн байна. Төсөл, арга хэмжээний санхүүжилт 100 хувийн гүйцэтгэлтэй байн.

3. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн даргын төсвийн 23 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар өөрчлөлтгүй дүгнэлт өгсөн. Санхүүгийн нэгтгэсэн тайланд 3 тайлан нэгтгэсэнээс 1 байгууллагын санхүүгийн тайлан дүгнэлт гаргаж, 2 байгууллагыг түүвэрт хамруулсан.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 86,4 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудлаар нийт 41,4 сая төгрөгийн 4 зөрчил илэрснээс зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлж, 41,4 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгсөн.

Тус Байнгын хороо аудитын дүн дүгнэлтээс үндэслэн дараах асуудалд анхаарал хандуулахыг зөвлөж байна. Төсвийн ерөнхийлөн захирагчдын хэрэгжүүлсэн хөтөлбөр, хөтөлбөрийг үр дүн, чанар, тоо хэмжээг төсвийн гүйцэтгэлтэй нь уялдуулан хяналт шинжилгээ, үнэлгээ хийж баталгаажуулах. Орлогын төлөвлөгөөг үндэслэлтэй төлөвлөж, орлогын гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах, Гадаад харилцааны сайд, Сангийн сайдын 2012 оны 2 дугаар сарын 21-ний өдрийн А18/50 дугаар хамтарсан тушаалаар баталсан Монгол Улсаас хилийн чанадад суугаа Дипломат төлөөлөгчийн газрын ажилтнуудад олгох зардал, хангамжийн тухай журамд байр түрээслэх, сургалтын төлбөр төлөх, суугаа орны эрүүл мэндийн даатгалд хамруулахтай холбоотой зохицуулалтыг тухайн орны онцлогт нийцүүлэн тодорхой болгох.

Зэвсэгт хүчний харьяа ангиуд байрлаж байгаа болон эзэмшлийн нууц болон маш нууц шийдвэрээр олгосон

газарт татварын хөнгөлөлт, чөлөөлөлт олгох асуудлыг судалж шийдвэрлэх. Худалдан авах ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулах, аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах. Төрийн аудитын байгууллагаас хийсэн аудитын дүгнэлтийг тоймлон танилцуулж дууслаа. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Г.Тэмүүлэн: Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд үндсэндээ болбол 5 байгууллага хамаарч байгаа. Гадаад харилцааны яам, Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, Онцгой байдлын ерөнхий газар, Цөмийн энергийн газрууд байгаа. Төсвийн ерөнхийлөн захирагч нарыг дуудна.

Одоогоор ирсэн байгаа хүмүүс албан тушаалтнуудыг би бас танилцуулчихъя. Цөмийн энергийн комиссын дарга Гунаажав Манлайжав дарга байна. Бямбацогт сайд хаана байна вэ? Батлан хамгаалахын сайд, Төрийн нарийн дуудаарай. Дагвадоржийн Ганхуяг БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, бригадын генерал хүрэлцэн ирсэн байна. Бадраагийн Оюунгэрэл мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, дэд хурандаа хүрэлцэн ирсэн байна. Гадаад яамнаас Бямбасүрэн даргаас өөр хүн байна уу? ГХЯ-ны Бодлогын газрын захирал Гүнтэвсүрэнгийн Бямбасүрэн, Чүлтэмийн Ганбат ГХЯ-ны Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга ирчихсэн байна. Лханаажавын Мөнхтүшиг ГХЯ-ны ТНБД байх ёстой, дуудна. Батмөнхийн Батицэцэг сайд Гадаад харилцааны сайд, төсвийн ерөнхийлөн захирагч, сайдыгаа дуудна. ЗХЖШ, ЗХЖШ-аас хүн байна уу? Эрдэнэбаяр, Пүрэвжавын Эрдэнэбаяр ЗХЖШ-ын Санхүүгийн хэлтсийн ахлах мэргэжилтэн гэсэн байна. ОБЕГ-аас одоо ирсэн байгаа нь Батмөнхийн Ууганбаяр ОБЕГ-ын дэд дарга, бригадын генерал, Төрмандахын Мөнх-Эрдэнэ ОБЕГ-ын Санхүү, ар талын газрын Төсөв, санхүү

хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, хошууч гэсэн байна.

Бусад төсвийн ерөнхий захирагч нарыг орж ирэх хүртэл бусад байгууллагын удирдлагуудыг танилцуулъя. Үндэсний аудитын газар Дэлэгийн Загджав Монгол Улсын Ерөнхий аудитор, Ядамын Самбууням Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч, Цэвэгсүрэнгийн Наранчимэг Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Дэлгэрийн Энхболд Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Оюунхүү Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын ахлах аудитор, Идэрбалжинням Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын аудитор, Нямжаргал Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын аудитор, Юрагийн Энхтуяа Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын аудитын менежер, Чанцалдулам Санхүү-нийцлийн аудитын газрын аудитын менежер. Лхагвацэнд Санхүү-нийцлийн аудитын газрын аудитын менежер.

Сангийн яамнаас Сангийн яамны ТНБД Ганбат дарга ирсэн байна. Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга Цогбадрах, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Лувсандоржийн Сонор Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Лувсанванданы Ичинноров Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга, Солонгын Тулга Сангийн яамны Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга, Нарангийн Мөнхсүх Сангийн яамны Төрийн сангийн Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга, Лувсандоржийн Гантогтох сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Булганхүүгийн Ганзориг Сангийн яамны хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Ванчингийн Рэнцэнханд Сангийн яамны Төрийн сангийн Төлбөр, тооцооны хэлтсийн дарга гэсэн ийм бүрэлдэхүүнтэй байна. Мөн дээрээс нь нэмж

Рэгжсийбуугийн Отгонжаргал Гаалийн ерөнхий газрын дарга бас хүрэлцэн ирсэн байна. Гишүүд, төсвийн ерөнхийлөн захирагч нарыг дуудаарай. Бямбацогт сайд, ГХЯ-ны ТНБД, сайд.

Төсвийн асуудал эрхэлсэн ЗГ-ын гишүүн, төсвийн ерөнхийлөн захирагч нараас төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлантай холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу? Гишүүдийн нэрсийг юу ч гэсэн авч байя. Энхбаяр гишүүнээр тасалъя. Энхбаяр гишүүн, нэрс асуулт асуух Ганбат гишүүн үү? Ганбат гишүүнээр тасалъя. Энхбаяр гишүүн асуулт асууна.

Ж.Энхбаяр: Орчихлоо доо, Сангийн яамнаас асуулт байна. Төсөв батлагдах нэг хэрэг, хамгийн гол нь гүйцэтгэл хэрхэн гарч байгаа тухай, ялангуяа энэ батлагдсан хөрөнгө оруулалт урсгал зардал бүрэн зарцуулагдаж байх учиртай. Тэгээд явц нь гүйцэтгэл нь яаж гарч байна гэдгийг нь хэлээдхээч. Аль байгууллага батлагдсан төсөв хөрөнгө оруулалтаа бүрэн дүүрэн зохион байгуулж, хэрэгжилтийг хангаж чадав? Аль яам, аль байгууллага дээр энэ хангалтгүй үр дүн гарчхав? Яагаад ийм байдал үүсэв. Тэгээд үүссэн учир шалтгааныг нэг сонсоодохвол дараа дараагийн төсөл хөтөлбөрөө батлах юман дээрээ бас бид байгаа боломж багтаамж юмаа бас тооцох нь зүйтэй гэж бодож байна.

Г.Тэмүүлэн: Ж.Энхбаяр гишүүний асуултад Сангийн яам хариулъя. 2 номер Ганбат дарга.

Ж.Ганбат: Энхбаяр гишүүний асуултад хариулъя. Сангийн яам бол төсөв батлагдсаны дараа бол Төсвийн хуулийг хэрэгжүүлэх ийм талд бол онцгой анхаарч бол зарим тохиолдолд бид бол улсын их юу ЗГ-аар Төсвийн хуулийг хэрэгжүүлэх бол ингээд мөрдөх тогтоол гаргадаг. Энэ дээр ялангуяа бид хөрөнгө оруулалтын ажил дээр онцгой анхаардаг. 11 сарын 15-нд төсөв батлагдангуут бид

худалдан авалтыг бол ялангуяа зохион байгуулах асуудлыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт бол даалгаж, үүн дээр бол бид 11 сарын 15-нд төсөв батлагдангуут энэ худалдан авалтын ажлаа зохион байгуулаад, тэгээд дараа оныхоо 4 сарын 1 гэхэд энэ бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлсэн байх ийм шаардлагыг бол Сангийн яам тавиад сүүлийн үед бол нэлээн явж байгаа.

Өмнөх жилүүдэд бол хөрөнгө оруулалтын гүйцэтгэл 70 гаруй хувьтай дунджаар 80 хувь, 80 гаруй хувьтай явдаг байсан бол сүүлийн жилүүдэд би нэгд Сангийн яам юунаас төсвийн ерөнхийлөн захирагчдын хөрөнгө оруулалтын гүйцэтгэл 90 гаруй хувьтай бол гарч байгаа. Яах вэ энэ юун дээр хөрөнгө оруулалтын гүйцэтгэл дээр бас нэг хүндрэлтэй асуудал үүсэж байгаа нь яг ажил явж байх явцын дундуур яах вэ нөгөө валютын хани болон зарим гол материалуудын үнийн өсөлттэй холбоотойгоор ийм хүндрэлтэй асуудлууд бол үүсэж байгаа.

Тэгээд бид бол юун дээр Төсвийн тухай заасны дагуу бас зохицуулалтын арга хэмжээнүүдийг батлагдсан төсвийн хүрээнд бол хөрөнгө оруулалтаар авч хэрэгжүүлдэг. Тэр ажлын гүйцэтгэл явцтай нь уялдуулаад, санхүүжилтийг жишээ нь хангалтгүй явж байгаа санхүүжилтийг бид нар яг батлагдсан төсөвт өртгийг нь өөрчлөхгүйгээр сайн явж байгаа руу нь зохицуулах байдлаар ингэж зохицуулалтын арга хэмжээнүүдийг авч бол онцгой анхаарч бол ингэж ажиллаж байгаа.

Тэгээд юун дээр 2023 оны гүйцэтгэл дээр Шадар сайдын багц дээр хөрөнгө оруулалтын гүйцэтгэл 99 хувьтай, Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайдын хөрөнгө оруулалтын гүйцэтгэл 82,6 хувийн гүйцэтгэлтэй. Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын даргын хөрөнгө оруулалтын гүйцэтгэл 98 хувьтай, БОАЖ-ын сайдын хөрөнгө оруулалтын гүйцэтгэл 97

хувьтай, Батлан хамгаалахын сайд 100 хувь, Сангийн сайдынх 98 хувь, ХЗДХ-ийнх 99 хувь, ХНХ-ын сайд 95 хувь, БХБ-ын сайд 97 хувь, Соёлын сайд 97 хувь, ЗТХ-ийн сайдынх 97 хувь, ХХААХҮ-ийн сайдынх 98 хувь, Эрчим хүчний сайдынх 99 хувь, Эрүүл мэндийн сайдынх 96 хувь гэдэг ийм байдалтайгаар, Цахим, хөгжлийн сайдынх 98 хувь байна. Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хороон даргынх 99 хувьтай.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Хариулт хангалттай юу? Ганбат гишүүн асуулт асууя.

Д.Ганбат: Энэ чинь юу шүү дээ. Бид нар гүйцэтгэл ярьж байна. Ер нь бол хаа сайгүй бол хулгай байна даа л гээд байгаа, хаа сайгүй бол хулгайлж байна даа, ашиглалт шамшигдалт энэ тэр байна гээд байгаа. Манай Байнгын хорооны харьяа 5 байгууллага яам, газрууд бол яах аргагүй төсвийг нь тавиад, тэрийг нь өгч байх ёстой ийм газар л даа.

Бусад яамд, төр нөгөө 40, 50 хувьтай ДНБ-ийг зарцуулаад, бүтээн байгуулалт хийнэ гээд байгаа, тэгээд яг гарт баригдаж, нүдэнд үзэгдэх юм байхгүй л дээ. Ер нь төрийн оролцсон юм болгон л тэр тусмаа манай сүүлийн үеийн 8 жилд оролцож байгаа энэ юм болгон нэг их тийм үр дүнтэй, бүтээгээд гаргаад байсан юм байхгүй байгаа. Хамгийн гол зүйл бол энэ урд хөршгүйгөө дэлхийн 2 дахь эдийн засаг болсон энэ эдийн засагтай холбогдож байгаа нөгөө төмөр замууд маань холбогдсон уу, тэр юу болсон бэ, энэ ороод явсан уу, ямар байгаа гэсэн нэг ийм асуулт байгаа.

Энэ гүйцэтгэл дээр гүйцэтгэл дээр ашиглалт шамшигдалт энэ юм гарсан уу? Тухайлбал ажиллах хүн олдохгүй байна гэж яриад байгаа. Орон тоо бол дутуу ажилласан гэж түрүүний Байнгын хорооны хурал дээр хэлнэ лээ. Тэр мөнгө төгрөг хэмнэгдэх үү? Ажил хийх сувилагч, эмч, багш нар энэ хүмүүс бол цалин пүнлүү

нь хүрэхгүй, амьдрал ахуйн эрхээр бол гадагшаа гараад ажиллаад байна. Манай дээр хүртэл цагдаа нарын орон тоо бол гүйцэт ажиллаж чадаагүй гэж байгаа. Тэгэхээр энэ мөнгө хэмнэгдэх үү?

Нөгөө талаар Сангийн яамныхан байгаа юм чинь би бас нэг зүйл тодруулчихъя. Манай Баянхонгор аймагт Хөдөө аж ахуйн кластер гээд төсөл хэрэгжиж байгаа юм. Уул нь бол энэ онуудад багтаад дуусах ёстой. Гэтэл ажлын гүйцэтгэл миний багцаагаар бол 50, 60 хувьтай л байгаа юм. Тэгээд миний дуулснаар бол тэр гүйцэтгэлээ 70, 80 хувьтай авчихсан байна гээд байх юм. Тэгээд тэр мөнгө төгрөгөө авчихаар тэр юмаа хийхгүй тэгээд таг болчихоод байгаа юм л даа. Тэгээд нөгөө хяналтгүй, хариуцлага тооцдоггүй ийм явдал газар сайгүй болсны л нэг жишиг нь энэ. Ер нь ийм ерөөсөө сүүлийн 8 жил, одоо ч байхгүй болох юм шиг байна. Хяналтгүй, хариуцлага тооцдоггүй, хуулиа барьдаггүй ингэж явсаар байгаад сурчихлаа л даа. Ийм дутагдлууд байгаа юм.

Тэгээд энэ юмны хажуугаар бас хэлэхгүй, ярихгүй, энэ чинь ийм байна шүү гээд ямар ч байсан хэлээд, яриад, протоколд нь тэмдэглүүлээд ингээд явж байх нь зөв байх. Тэгээд л бүгдээрээ дуугүй яваад байвал энэ ард түмний хөрөнгө мөнгө гарын салаагаар урсаад л, хэнд ч хариуцлага тооцдоггүй гэсэн маягтай өнгөрөөд л, ер нь хариуцлага.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Асуултад хариулъя. Сангийн яам Ганбат дарга номер 2.

Ж.Ганбат: Гишүүний асуултад хариулъя. Ер нь бол улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээнүүдийг захиалагч нь яг газар дээрх хяналтыг тавьдаг. Жишээ нь Баянхонгорт хэрэгжиж байгаа ХАА-н кластер төслийн газар тариалангийн малын тэжээлийн дэд төсөл гээд байгаа, энэ дээр нийт 10 тэрбумын төсөвт

өртөгтэйгөөс 4,2 тэрбумыг авсан. Энэ санхүүжилт нь ер нь яаж явдаг вэ гэхээр захиалагч нь хяналтаа, тэгээд гүйцэтгэлийг нь баталгаажуулаад, тэгээд холбогдох бүх албан тушаалтнууд гар хөлийн үсгээ зураад, тамга тэмдгээ дараад, тэгээд Сангийн яам руу илгээж байгаа юм. Сангийн яам түүн дээр нь үндэслээд санхүүжилтийг бол олгодог.

Нөгөө талдаа энэ ажлын хангалтгүй явж байгаа энэ асуудлууд дээр бас Сангийн яамнаас бол энэ онцгой анхаарч энэ компаниудыг ер нь тэр саарал жагсаалтад оруулах асуудал дээр бол онцгой анхаарч байгаа. Ингээд улирал болгон ... дээр нь энэ удаа дараа ийм тендерийн худалдан авалтыг хийчхээд, хугацаандаа оруулахгүй, тэгээд бас чанарын шаардлага хангаагүй энэ компаниудад бол хариуцлага тооцож, бид юунд дахин тендерт оролцохгүй байх талаар хар, саарал жагсаалтад оруулж, энийг бол олон нийтэд бол мэдэгддэг бол ийм бол арга хэмжээнүүдийг бол авч байгаа.

Г.Тэмүүлэн: Аудит нэмж хариулах уу? Самбууням дарга 5 номер.

Я.Самбууням: Үндэсний аудитын газар Самбууням байна. Ганбат гишүүний асуултад хариулъя. Ер нь болбол энэ Байнгын хороонд хамрагдах төсвийн ерөнхийлөн захирагчдын зардал болбол хэмнэгдсэн юм байхгүй. Ерөнхийдөө болбол 2023 онд болбол нөгөө төрийн албан хаагчдын цалингийн өсөлтөөс шалтгаалаад урсгал зардал нь болбол өссөн байдалтай байгаа. Нийт зарлага, цэвэр зээлийн дүн 4 их наяд 349,3 тэрбум төгрөгөөр өссөн. Энэний урсгал зарлага нь болбол 2 их наяд 862,1 тэрбум төгрөг, хөрөнгийн зардал 1 их наяд 384,8 тэрбум төгрөг байгаа. Энэ болбол нийтдээ нийт урсгал, улсын урсгал зардлын хувьд хэлсэн байгаа. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Ганбат гишүүн нэмж тодруулъя. Ганбат гишүүний микрофон.

Д.Ганбат: Тэр аудитын ярьж байгааг ойлголоо. Сангийн яам тэр юман дээрээ анхаараарай тийм. Нөгөө талаар бол энэ бүрэн гүйцэт хүмүүс ажиллахгүй байна, орон тоон дээр ажиллах хүн олдохгүй байна, хөдөө орон нутагт төрийн албан хаагч дутагдалтай байна гээд л ингээд яриад байгаа л даа. Ер нь тийм ч байгаа. Тэр цалин мөнгө нь хаачдаг юм бэ тэгээд? Ажиллаагүй бол. Улсын төсвийг батлахдаа бол бүтэн жилээр нь бүх юмыг нь батлаад л өгч байгаа шүү дээ. Тэгээд хэмнэгдсэн юм ерөөсөө алга гээд байх юм. Тэр хэмнэх юу байх вэ, ажиллаагүй хүний цалин тэр чигээрээ л үлдмээр юм. Энийг нь хааш нь яагаад, яачихдаг юм бэ? Энэ тэгээд яг явдаг юм явдгаараа явж байна уу эсвэл ямар учиртай юм болоод байна вэ? Бүр тэр багш мэргэжлийн бус хүнийг ч ажиллуулъя гээд л зарлал гаргаж байх жишээтэй. Энэ улс орон чинь юу болоод байна вэ?

Ингээд л хараад байхад бүх юм хэвийн юм шиг хэдэн хүн ирчихсэн ингээд байгаад байдаг. Яг хариуцах ёстой нэгдүгээр гарын үсэг зурдаг, тамгаа дардаг хүмүүс нь байхгүй. Нөгөө хаа сайгүй л хулгай, луйвар явж байна тийм ээ гэж ярьдаг шиг, улс орноор сонин юу байна гэхээр хаа сайгүй л хулгайлж байна, хаа сайгүй л луйвардаж байна. Яагаад ийм байна вэ гэхээр хариуцлага ярихгүй, хяналт тавихгүй ийм байдлаас болж байна. Төр нь улам данхайж байна, орон тоо нь улам ихсэж байна. Бид нар ярихдаа бол энийг цомхон, ард түмэнд үйлчилгээг ойртуулна гэж яриад байдаг. Энийг чинь л асуугаад байна шүү дээ. Тэгээд хэлэхгүй, ярихгүй байна гэдэг. Тэгээд энийг нь хэлэх ярихаар яг тодорхой хариулт өгдөггүй. Тэгс ингэс хийгээд өнгөрдөг.

Г.Тэмүүлэн: Ганбат гишүүний асуултад хариулт өгье. Хэмнэлт хийгдсэн төсвүүд яаж байгаа вэ? Сангийн яамны ТНБД Ганбат дарга 2 номер.

Ж.Ганбат: Бид ерөнхийдөө яах вэ 2023 оны урсгал зардал бол 95, 96 хувийн ингээд гүйцэтгэлтэй буюу ингэж бол гарсан байгаа. Яг байгууллагууд дээр бол цалингийн зардал дээр бол нөгөө орон тоогоороо бүрэн ажиллахгүйгээр өвчтэй, чөлөөтэй, жирэмсний амралттай энэ тэр гэдэг ийм байдлаар бол явдаг. Тэрэнтэй холбогдуулаад бол яах вэ цалингийн зардал байгууллагууд дээр бол хэмнэлттэй гардаг ийм юмнууд бол байгаа. Цалингийн хэмнэгдсэн зардлыг бол бид яг хэмнэгдсэнээр л гаргаж байгаа юм. Яах вэ бид нар өөр зардал хооронд нь шилжүүлэхгүйгээр цалингийн зардлыг бол хэмнэгдсэн дээр нь ингэж бол гаргадаг. Ийм байдлаар бол байгаа.

Нөгөө талдаа бид цалингийн цахим системийг нэвтрүүлээд сүүлийн 3 жил бол ингээд ажиллаж байна. Тэгэхээр энэ дээр бол бид одоо нөгөө тэрнээс өмнөх жилүүдэд байдаг шиг цалингийн зардлыг ашиглан хэлбэрээр ашиглах, өөр зүйлд зарцуулах юм бол байхгүй. Яг л тэр ажилласан төрийн албан хаагчдын яг тэр ажлын ирц юмнууд дээр нь үндэслээд, тэгээд цалинг бол шууд цахим байдлаар бол ингээд цахимжуулаад цалингийн мэдээллийн нэгдсэн сантай. Энэ сан бол тухайн төсвийн ерөнхийлөн захирагч, Сангийн яам, Төрийн албаны зөвлөл ингээд хоорондоо ингээд холбогдчихсон. Энэ дунд өөрөөр хэлбэл ямар нэгэн орон тоо болон цалингийн хийдэл гаргахгүйгээр ингэж бол цалин дээр бол хяналттай бол ажиллаж байгаа.

Төсвийн байгууллагуудын ажилчдын бол яах вэ хөдөө орон нутагт тодорхой ингээд ажиллах хүн олдохгүй байна гэдэг дээр бол хөдөө орон нутгийн нэмэгдлүүдийг тухайн салбар салбарын онцлогоос нь хамаараад 5 жил, 6 жил, ингээд 4 жил энэ тэр гэсэн нэмэгдлүүдийг бол олгоод явж байгаа. Нөгөө талдаа төсвийн энэ дээр өнгөрсөн 2023 онд бол нийтдээ бол гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн зарчим тэгээд үндэслээд энэ байдлаар санхүүжиж байгаа нийт 23602 албан хаагчид бол 25,7 тэрбум

төгрөгийн урамшуулал өгсөн. Нөгөө талдаа хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан тул ЗГ-аас сүүлийн 2.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Ганбат гишүүн нэмж тодруулъя. Сүүлийн тодруулга байгаа.

Д.Ганбат: Манайх чинь янз янзын юм их гарах юм. Тэр энэ сонин хэвлэл энэ янз бүрийн олон нийтийн сүлжээ дээр явж байгаагаар бол том нь том хулгай хийж байна, жижиг нь жижиг хулгай хийж байна. Тэгээд энэ орон тоонд, орон тоон дээр хүмүүс ирэхгүй байна, ажиллахгүй байна гээд байдаг. Тэгээд энэ чинь ард иргэд маань авах ёстой үйлчилгээгээ авахгүй байна л гэсэн үг 1 дүгээрт.

2 дугаарт тэр орон тоон дээр ямар нэгэн байдлаар өөрсдийнхөө танил, ах дүү садан энэ тэрээ юмнуудаа биччихсэн, тэгээд тэр цалинг нь өгөөд байдаг гэсэн ийм юм явж байгаа байхгүй юу. Олон улсын байгууллага энэ тэр бол тэр харьяа юмаа бол судалж бариад гаргачихдаг л юм байна л даа. Ийм юм болсон байна гээд байгаа байхгүй юу. Манай дээр бол тийм юм ерөөсөө байхгүй. Юу ч болоогүй юм шиг л яваад байдаг. Тийм юм байдаг юм уу, байдаггүй юм уу, тэрийг нь бас хянаж шалгадаг, энд үздэг хардаг юм байх уу? Тэр мөнгөө бол бүгд л аваад, цалингаа хэрэглээд ингээд дуусчихсан л байдаг юм байна л даа.

Тэгсэн мөртөө орон тоон дээрээ хүн авахгүй эсвэл хангалттай цалинг нь өгч чадахгүй. Нөгөө үйлчилгээ нь дутуу хүрдэг ард түмэнд ингээд эцсийн эцэст энэ Монголчууд, Монголын ард түмэн, иргэд л хохироод байгаа байхгүй юу. Энийг чинь хэн нэгэн хэлж ярих хэрэгтэй болчихоод байдаг. Тэгээд хэн нэг нь хэлээд байгаа бол би дуугүй л байчихмаар байна л даа.

Г.Тэмүүлэн: Ганбат дарга 2 номер.

Ж.Ганбат: Өмнө нь бол тийм цахим системд оруулаагүй байхад бол яг таны хэлээд байдаг байсан ийм асуудлууд үнэхээр гардаг байсан ийм зөрчил. Ажиллаагүй хүнийг ажилласан мэтээр цалинг нь авдаг, ерөнхий нягтлан тухайн байгууллагын дарга 2 хий хүн ажилласнаар бүртгүүлж, цалинг нь авдаг, ашиглан хийдэг, ах дүү нараа оруулж бүртгүүлж. Энийг бид ерөнхийдөө байхгүй болгох, энэ дээр хяналт тавих зорилгоор цалингийн нэг цахим систем гэдэг юмыг бүрдүүлээд, Төрийн албаны зөвлөл, төсвийн ерөнхийлөн захирагч, Сангийн яам 3 ингээд холбочихсон энийг хэрэгжүүлээд явж байгаа. Энэнээс хойш бол ийм юм гараагүй.

Нөгөө талдаа төсвийн ерөнхийлөн захирагч болгон дээр дотоод хяналт, дотоод аудит гэдэг бол байгаа. Эд нар бол бас хараат бус байдлаар тухайн байгууллагууд дээрээ бас хяналт явах тавих ийм чиг үүрэгтэй бол ажиллаж байгаа. Би түрүүнд бас нэг юм нэмэлтээр хэлэхэд тухайн орон нутагт тогтвор суурьшилтай ажиллахын тулд ажиллуулахын тулд ЗГ-аас ипотекийн зээл дээр хөнгөлөлттэй 3 хувь гэдэг юмыг хэрэгжүүлээд 2 жил болж байна. Орон нутагтаа энэ Улаанбаатар хотоос хөдөө орон нутагт ажиллаад тогтвор суурьшилтай ажиллах юм бол 6 хувийн ипотекийн зээлийг 3 хувийн хүүтэйгээр ингээж олгох энэ төслийг хэрэгжүүлээд бол хэрэгжүүлээд ажиллаж байгаа.

Нөгөө талдаа тухайн орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан тохиолдолд нэмэгдлийг нь орон нутаг өөрсдөө шийдвэрлэх бас Улаанбаатарт ажилласнаас илүү нэмэгдэл олгох энэ тэр гэдэг ийм ийм тогтвортой ажиллуулахын тулд ЗГ-аас тодорхой үе шаттай арга хэмжээнүүд авч хэрэгжүүлж байгаа.

Г.Тэмүүлэн: Ойлголоо, гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлантай холбоотой үг хэлэх гишүүд

байна уу? Гишүүдийн нэрсийг авъя. Алга байна.

Ингээд Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд танилцуулах учиртай байгаа. Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны гишүүн байгаа билүү манайд, манайд байхгүй юу? Шижир гишүүн танилцуулах уу? Хосбаяр гишүүн танилцуулах уу та Зарлагын хяналтын дэд хороонд? Хосбаяр гишүүн танилцуулчихъя. Ингээд Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны гүйцэтгэл, Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон Монгол Улсын 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа. Ажлын хэсгийнхэнд баярлалаа.

12.47 цаг

Ингээд хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн Байнгын хорооны хуралдаан дууссаныг мэдэгдье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.УЯНГА

